

## УЛС ТӨР БА ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХАРИЛЦАН ХАМААРЛЫН АСУУДАЛД

С.Базарпүрэв

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш, доктор, дэд профессор

“Улс төр”, “иргэний хөдөлгөөн” гэсэн сэдэв нийгмийн харилцаа, хэрэглээний эргэлтэнд идэвхтэй яригдах болсон нь цаанаа зарчмын чухал агуулгатай гэдгийг харуулж байна. “Улс төр”, “иргэний хөдөлгөөн” нь үзэл суртал төдийгүй олон улсын хоорондын маргаан болж, хууль эрх зүйд өөрчлөлт оруулж, иргэний нийгмийн үйл ажиллагаа мөн хүмүүсийн амьдралд эерэг болон сөргөөр нөлөөлдөг.

Иргэд улс төрийг бага сонирхдог. Тэд өөрийн гэсэн амьдралтай, ажил эрхлэх гээд улс төрийн мөн чанар, ач холбогдлыг тайлж мэдэх зав тун хомс. Иргэний хөдөлгөөний утга учир, чиг хандлагыг тэр болгон ойлгож, ухаарсан иргэд ч бас ховор.

“Улс төр”, “иргэний хөдөлгөөний” асуудлыг тусгай мэргэшсэн алба, субъект хариуцан, тухайн сэдвийг судлан, учир холбогдлыг тогтоож, дэг журмын дагуу хэлэлцэн, яаж шийдвэрлэх арга хэрэгсэл, хэн ямар үүрэг хүлээж оролцохыг тодорхойлодог. Тухайн албаны үйл ажиллагаанаас “иргэний хөдөлгөөнийн” асуудал хэрхэн нааштай шийдвэрлэгдэх нь шалтгаалдаг байна. “Иргэний хөдөлгөөний” асуудал байнга л хурцад мал байдалд байдаг ба түүнийг шийдвэрлэхэд хүндрэл ямагт гардаг.

“Улс төр”, “иргэний хөдөлгөөнийн” асуудлыг энгийн иргэд төдийгүй тухайн салбарын зарим судлаачид хүртэл “хольж хутгах” тохиолдол гардгаас үүдэн тодруулга хийх шаардлагатай асуудал үүсдэг билээ.

Яагаад иргэний хөдөлгөөн улс төржиж байна?

Иргэний хөдөлгөөний нийгэмд хандсан үйл ажиллагаа улс төрийн хучний үйлдэлтэй ижил төстэй болоод байгаагийн учир юунд байна?

Улс төрчид иргэний хөдөлгөөнийг өөрийн талд татан оруулах сонирхол юунаас үүдэлтэй вэ?

Иргэний хөдөлгөөний үйл ажиллагааг улс төрийн тэмцлээс салгах хэр чухал вэ? гэсэн дээрх асуудалд хариу өгснөөр “иргэний хөдөлгөөний” мөн чанарыг зохистой ойлгох боломж олдох юм.

Нийгэмд иргэд “улс төрөөс” уйдаж, залхах хандлага ямагт давамгаалж байдаг. Улс төрд зохисгүй агуулга оруулан нийгэмд нэвтрүүлснээр иргэд түүний мөн чанарыг ташаа ойлгож, “бохир” гэсэн тодотгол өгч, хүн ойртох хэрэггүй “орчин” хэмээн үздэг. Үүний үр дүнд улс төрд оролцох нийгэм, улс гүрнээ гэсэн бодолтой иргэдийн тоо цөөрч, “улс төрийн элит” нэртэй олигарх “хар” хэргээ гүйцэлдүүлэх боломж нээгддэг. Ийм нөхцөлийг өөрчлөх гэсэн эрүүл хүч идэвхжиж хаяа сэrdэг ч гэсэн тодорхой хийх ажил нь онолын үндэслэл хийгдээгүй учир амжилтанд хүрэлгүй замхардаг тохиолдол элбэг юм.

Улс төрийн ямар ч ойлголт өөрийн гэсэн агуулгатай мөн тодорхой хэрэглээний зориулалттай байдаг гэдгийг анхаарах нь зүйтэй.

“Иргэний хөдөлгөөн” гэсэн ойлголт түгээмэл хэрэглэгдэж ихэнх улс төрийн болон улс төрийн ойр хүч өөрсдийгээ иргэний эрх хамаалагч гэх болжээ. Засгийн эрх барьж байгаа, засаглагч болох гэсэн санаатан иргэний эрх хамгаалагч дүр эсгэх нь түгээмэл үзэгдэл болсон байна. Зарим нь Иргэний эрх хамгаалагчдийн олон жилийн туршид хэрэгжүүлсэн уйгагүй үйл ажиллагааны үр дагавар болон төлөвшөөн нэр хүнд, ололт амжилтанд нь очиж наалдах гэсэн сонирхолдоо хөтлөгдөн иргэний эрх ярьdag байхад нөгөө нь иргэний эрхийн асуудлыг үгүйсгэх гэсэн зорилго агуулсан байдаг.

Иргэний эрх хамгаалагчдын дунд ч “иргэний хөдөлгөөн”, “улс төрийн тэмцлийн” хооронд буй үндсэн ялгааг тэр бүр ойлгохгүй байх нь ажиглагдаж байна. Зарим орон нутгийн болон шинээр үүссэн байгууллагыг ямар салбарт хамааруулах нь тодорхойгүй юм.

Улс төр, иргэний эрх хамгаалагчдыг хооронд нь хольж хутгах хандлага байгаа нь нийгмийг төөрөгдүүлэх үйл явцыг гүнзгийрүүлж улмаар таагүй үр дагавар гарах нөхцөл бүрэлддэг.

Үүнтэй уялдан нэгдүгээрт, “улс төрийн тэмцэл”, “иргэний хөдөлгөөн” (Хүний Эрх хамгаалах үйл ажиллагаа) гэсэн бие даасан иргэдийн оролцооны хоёр төрөл нь орчин үеийн төр улс, нийгэмд чухал шаардлагатай, хоёрдугаарт, дээрх хоёр төрөл нь зорилго, тэмцлийн арга барил, хэрэгслийн хувьд хоорондоо эрс ялгаатай, зарим тохиолдолд эсрэг байр суурьтай байдаг, гуравдугаарт, тухайн хоёр төрлийг адилтгаж үзсэнээр иргэний эрхийг хамгаалах чадваргүй тогтолцоо үүсэж, улс төрийн тодорхой бус байдал тогтон, нийгэмд хор холбогдолтой үр дагавар гарна гэдэгт тодруулга хийх хэрэгцээ, шаардлага гардаг.

Улс төрийн нэр томъёоны агуулга, мөн чанарыг зохистой ойлгохын чухалыг дээр сануулсан билээ. “Улс төр” гэсэн ойлголт нь англи хэл дээр “Politics”, “Policy” гэж хоёр янзаар тэмдэглэсэн байдаг.

“Politics” гэдэг нь тодорхой төвшинд улс төрийн засгийн эрхийн төлөө хийх тэмцлийн тавцан. Уг салбарт иргэний эрх хамгаалагчид, шаардлагагүй тохиолдолд оролцдоггүй.

“Policy” гэсэн нэр томъёог “нийгмийн бодлого” хэмээн ойлгох учиртай. Улс төр ч биш юм. Тодруулбал, зорилго чиглэлтэй үйл ажиллагааны бодлого гэсэн утгатай. Үүнтэй уялдаатай бид залуучуудын талаар явуулах бодлого, нийгмийн бодлого, хууль, эрх зүйн бодлого гэж ярьdag. Иргэний Эрхийн асуудлыг авч үзэх бодлого нь нийгмийн бодлогын нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Төр өөртөө хүлээсэн иргэний эрхийг хамгаалах үүргээ чанартай, цаг тухайд нь биелүүлж байхад чиглэгдсэн л үйл ажиллагаа. Иргэний эрхийг хамгаалагчид тухайн салбарт татагдан орж идэвхтэй ажиллагаа явуулдаг.

Бүх шатны сонгуулийн үед иргэний эрхийг хамгаалах, шударга явагдаж буй эсэхийг хянах нь иргэний эрх хамгаалагчдын хийх ёстой үндсэн ажилд тооцогддог. Засгийн эрх барьж буй улс төрийн хүчээр Үндсэн хуульд заагдсан улс төрийн эрх биелэх нөхцөл, боломжийг бүрэн хангуулахын төлөө иргэний эрхийг хамгаалагчдын хийж байгаа үйл ажиллагаа юм.

Мөн үүний зэрэгцээ иргэний эрхийг хамгаалагчдын хийх учиртай бас нэг ажил нь нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх явдал юм. Юуны өмнө сонгуулийн байгууламжинд итгэх ард түмний итгэлийг бүрдүүлэх. Хоёрт, төрийн шийдвэрт иргэдийн оролцох эрхийг хангах. Гуравт, ямар нэгэн улс төрийн нам, хүчний нэр дэвшигчийн сонирхол, эрх ашгийг хамгаалахгүй байх явдал.

Иргэний эрх хамгаалагчид, иргэний хөдөлгөөний нийгмийн үйлдэл, жагсаал цуглаан зэрэг нь улс төрийн арга хэмжээтэй нэн төстэй байдаг. Эрх баригчдын бодлого үйл ажиллагааг хурц шүүмжлэн амлалтаа биелүүлэхийг шаардах нь улс төрийн тэмцэл хийж буй мэт болдог.

Иргэний хөдөлгөөн, улс төрийн үйл ажиллагааны хооронд зарчмын ялгаатай. Иргэний эрх хамгаалагчид болон иргэний хөдөлгөөн нь нийгэмд тулгамдсан асуудлыг төр засгаар шийдвэрлүүлэх, хүний эрхийг хамгаалах зорилго агуулсан байдаг. Иргэний эрх хамгаалагчид нь эрх баригчдын хууль бус үйлдлээс иргэдээ хамгаалах, засаглагч иргэний хооронд зуучлагч-модератор үүрэгтэй юм. Иргэний эрх хамгаалагчдын үйл ажиллагаа нь хурц хэлбэртэй, хатуу шүүмжлэл хийдэг ч улс төрийн эрх авах, засаглагчийг гутаан доромжлох эрхгүй, зорилгогүй юм.

Нийгмийн асуудал, иргэний эрхийг хамгаалах үйл ажиллагааг системтэй шийдвэрлэхийн тулд засаглагчтай хэлэлцээр хийж, хамтран ажиллаж үүний үр дүнд асуудлыг шийдвэрлэх, шинэ дэг журам, системийг бүтээж хүний эрхийг хамгаалах үр бүтээлтэй тогтолцоог бий болгох нь нэн чухал юм.

Харин улс төрийн сөрөг хүчин нь одоо байгаа эрх баригчдын сул талыг шүүмжлэн засгийн эрхэнд гарч засаглал тогтоох зорилготой ч шинэ засаглагч нь мөн л хүний эрхийг зөрчсөн хэвээр л байдаг. “Хүмүүс шинэ засаглагч илүү сайн гэдэгт итгэн хуучны эсрэг дуртайяа босдог ч туршлага дээрээ удалгүй хууртсанaa мэддэг. Учир нь шинэ засаглагч хуучнаасаа ямагт доор байдаг” хэмээн Н. Макиавелли тэмдэглэсэн байдаг.

Иргэний эрх хамгаалагч нь нийгмийн сонирхол илэрхийлэх явцдаа засаглагчтай тэрслэхгүй зөвхөн шүүмжлэгч, ялангуяа хамтрагч байр сууринаас түүнтэй харьцах нь нийгмийн ашиг сонирхол, хэрэгцээнд илүү нийцнэ. Тухайн хууль, тогтоол, зарлиг зэрэг эцсийн шийдвэрийг тодорхой эрх баригч, засаглагч гаргадаг. Нийгмийн сонирхлыг хамгаалсан ямар ч үйлдлийн үр дүн нь иргэнд нэн чухал хэрэгтэй шийдвэр болдог.

Засаглагч нийгмээс гарч буй иргэний хөдөлгөөний үйл ажиллагаанд хүлээцтэй, тэвчээртэй эерэг нааштай хандах нь зүйтэй. Эс тэгвээс нийгмийн эрх ашиг хохирч иргэний болон төр засгийн үйл ажиллагаа нь үр дүнгүй, хий цаг алдсан, хүч тарамдсан ажил болж, ард түмний өмнө нэр хүндээ алдах явдал гарна.

Иргэний хөдөлгөөн, иргэний эрх хамгаалагчид засаглагчтай дайсагнах, улс төржих нь аль алинд нь хор холбогдолтойг дээр сануулсан. Хэдийд улс төрийн тэмцэл явагдаж байна, хаана нийгмийн сонирхол хөндөгдөж, хүний эрхийн асуудал яригдаж байна гэдгийг нэн тодорхой ялгаж салгах учиртай.

Иргэний хөдөлгөөн, иргэний эрх хамгаалагчид улс төрд бодолгүй хэт хутгалдах нь хүмүүсийн дунд төөрөгдөл төрүүлж, үл итгэх, үгүйсгэх үзэл төлөвшүүлэх хандлагыг бий болгодог. Тиймээс улс төрөөс ангид байхыг хичээх нь иргэний эрх хамгаалагчдын баримтлах чухал зарчим, байр суурь юм.

Засаг баригч эсхүл засгийн эрхийн төлөө тэмцэж байгаа улс төрийн хүч иргэний эрхийг хүлээн зөвшөөрч, үр өгөөжтэй хамгаалах нь түүний улс төрийн гол зорилгodoо хүрэх чухал нөхцөл, үндсэн болзол нь болдог. Улс төрийн эрх мэдэлтэн иргэний болон хүний эрхийг хамгаалах амлалт өгч засгийн эрхэнд гарч ирсэн тул түүнийгээ биелүүлэх эрхэм үүрэг, хариуцлага хүлээсэн байдаг.

Иргэдийн эрхийг хамгаалагчид “нийгмийн асуудлыг” шийдвэрлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад төрийн засаглалын төлөө тэмцэлдэх хэрэггүй ч иргэний эрхийг хавчиж, боймолсон улс төрийн гаж тогтолцоог халах үзэл санааг урьтал болгосон улс төрийн бодлогыг хэрэгжүүлж буй улс төрийн хүч, намын ажиллагааг дэмжиж байх үүрэгтэй. Иргэний эрх хамгаалагчид сайн дурын үндсэн дээр өөрийн ажлаа гүйцэтгэж нийгэмд үйлчилж байдаг онцлогтой, үр бүтээлтэй үйл ажиллагаа юм. Засаглагч улс төрийн намын хийж чадахгүй эсхүл хийх хүсэлгүй байгаа нийгэмд өгөөжтэй, хэрэгтэй зүйлийг тэд хийдэг.

Иргэний эрх хамгаалах ажлын мөн чанар, агуулгыг нарийвчлан тодотгох явцад иргэний эрхийн асуудлыг улс төрөөс салгаад зогсохгүй мөн бусад иргэний идэвхиэс ангид авч үзэх нь ач холбогдолтой байдаг. Нийгмийн сонирхлын бусад хэлбэр ч ийм байр суурьтай байх нь чухал. Нийгэмд өрнөж байгаа иргэдийн идэвхтэй үйл ажиллагаа, тулгараад байгаа нийгмийн асуудлыг төрөлжүүлсэнээр засаглагч улс төрийн хүч тууштай бодлого баримтлах, үйл ажиллагааны тодорхой хэлбэрийг сонгон, зохицой шийдвэр гаргах давуу талтай гэж дүгнэж болно.

Төр засгийн эрхийг барьж буй улс төрийн хүчиний шударга бус үйл ажиллагаатай уялдан улам хүндрэлтэй болж байдаг “нийгмийн асуудал” нь иргэдийн дийлэнх хэсгийг хамарч байдаг. Ийм шударга бус үйлдлийг гурав ангилж болно. Нэгд, иргэний эрхийг зөрчиж байгаа асуудал орно. Иргэний эрхийг зөрчсөн тохиолдолд шударга ёсыг тогтоо шүүх, шүүхийн бус, үндэсний болон олон улсын хэмжээнд зохицуулах нөхцөл боломж, хариу авах арга хэмжээ хангалттай бүрэлдсэн. Хоёрт, иргэний эрхэд хамаарахгүй эрх, хуулийг зөрчсөн асуудал түгээмэл байдаг. Гуравт, хүний амьдралд чухал ч гэсэн иргэний эрхийн асуудалд хамааруулж болохгүй шударга бус үзэгдэл нийгэмд олон тохиолддог. Хуулиар зохицуулах боломжгүй, тийм хууль ч байдаггүй.

Тиймээс иргэний эрхийг хамгаалагчдын идэвхтэй үйл ажиллагаа нь дээрх шударга бус үйлдлийг арилгах чухал хүчин зүйл, боломж болон нийгэмд тодроод байна. Гэвч энд бас л асуудал үүсдэг. Учир нь иргэний эрх хамгаалагчдыг төрт ёстой тэрслэн шуугиан тарьж, олон улсын тавцанд төр засгийн нэр хүндийг унагаж байна гэсэн гэм үүрүүлэх санаа эх баригчдад ямагт байдаг ч иргэний эрх хамгаалагчид төрийн эрх баригчийн байр суурийг бэхжүүлж байдаг зүй тогтолтойг олж харж болно. Засаглагч мөн төр засгийн оршин тогтнолын хүч нь иргэдийн түүнд үзүүлж буй итгэл юм.

Иргэний эрх хамгаалагчид төр засгийг шүүмжлэн, эрс буруутгах эсхүл магтан сайшаах нь эерэг үр дүн гарах алхам болж, хүний төлөө тавих анхаарал сонирхол нь сэргэх шалтгаан болдог. Төр, иргэнд хэрэгтэй гэдгийг сануулахад мөн төр иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах нэн чухал үүргээ биелүүлэхэд хүний эрх хамгаалагчид их нэмэр тустай.

Иргэний эрх хамгаалах салбарт төрийн хийж чадахгүй, амжихгүй, боломжгүй байгаа зүйлийг иргэний эрх хамгаалагчид сануулдаг гэдгийг дахин дурьдаад засаглагч үүнийг ойлгон иргэний байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах нь төрийн нэр хүнд өсөх, хүч нөлөө нэмэгдэх талтай юм. Ийм нөхцөлд төр түүнийг засаглагч хүнэлэг чанартай болж, нийгэмд хүчтэй донсолгоон гарах магадлал багасдаг.

Улс төрийн болон төрийн засгийн эрхийг ямар ч улс төрийн хүч барьсан иргэний эрх хамгаалагчдын хийх ажил тууштай, системтэй, тасалдахгүй байх учиртай.

**Түлхүүр үг:** Иргэний эрх, "Улс төр", "иргэний хөдөлгөөн", Иргэний эрх хамгаалагчид, Засаг баригч

**Товч хураангуй:** Засгийн эрх "сайн" хүмүүсийн гарг орсоноор хүний эрх зөрчих ажиллагаа дусгавар болно гэвэл эндүүрэл болох юм. Ямар ч засаглалын үед хүний эрх зөрчигдэж, хамгаалагдаж байдаг. Үүнд засаглалын мөн чанар оршино. Тиймээс ч Иргэний эрх хамгаалагчид, Засаг баригч наарт иргэний эрх хамгаалах тогтвортой үйл ажиллагаагааг тууштай хэрэгжүүлэх хэрэгцээ байна.

## РЕЗЮМЕ

Если завтра к власти придут одни хорошие люди, то сразу не будет нарушений прав человека. Это не правда. Нарушений прав человека будут при любой власти. Такова природа власти. Как, с другой стороны, ее задача – защищать права человека.

И поэтому у правозащитников, работы всегда будет много. Кто бы ни был у власти. И как бы мы к ним ни относились. Если правозащитники системно и последовательно готовы постепенно год за годом, менять ситуацию и решать проблемы защиты Прав Человека –то в обществе будет согласия и гармония.